МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишгээгийн НЯМБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-00-25, Факс: 32-70-16
E-mail: nyambaatar@parliament.mn
http://www.parliament.mn

2023 07. 05 № УИХ-03/6196

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

Хянан шалгах түр хороо байгуулах
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг тус тус үндэслэн "Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудаас экспортын нүүрсийг олборлох, худалдах, тээвэрлэх, гаалийн бүрдүүлэлт хийх, бусад гэрээ, хэлцэл хийх, худалдан авах ажиллагаанд Монгол Улсын хууль, тогтоомж зөрчигдсөн эсэх, энэ хүрээнд үйлдэгдсэн авлига, албан тушаалын гэм буруутай үйлдлүүдийг илрүүлэн шалгаж, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах" үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.НЯМБААТАР

Б.ЭНХБАЯР

С.ГАНБААТАР

Т.ДОРЖХАНД

П.АНУЖИН

Э.БАТ-АМГАЛАН

Ж.БАТЖАРГАЛ

2023082

Ж.БАТСУУРЬ

Э.БАТШУГАР

Х.БУЛГАНТУЯА

Н.ГАНИБАЛ

Б.ЖАРГАЛМАА

Г.ЗАНДАНШАТАР

Ц.ИДЭРБАТ

Л.МӨНХБААТАР

С.ОДОНТУЯА

Д.ӨНӨРБОЛОР

Ж.СҮХБААТАР

Д.ТОГТОХСҮРЭН

Д.ЦОГТБААТАР

Ж.ЧИНБҮРЭН

Г.ТЭМҮҮЛЭН

2023082

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАР

"ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ЗАРИМ КОМПАНИУДЫН НҮҮРС ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТ, БУСАД БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна." гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Монгол Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна." гэж тус тус заасан.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад гарч байгаа "нүүрсний хулгай"-н асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь энэхүү асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

1.2.Практик шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниуд, ялангуяа төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудад гарсан "Нүүрсний хулгай"-н асуудлаар иргэд, олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй, Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй, гэмт хэргийн шинжтэй мэдээллүүдийг тодорхой болгох, хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа "нүүрсний хулгай"-тай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байна.

Үүний тулд Улсын Их Хурлаас төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт,

экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах арга хэмжээ авах, тус үйл ажиллагааг явуулах Хянан шалгах түр хороог Монгол Улсын Их Хурлаас хуулийн хүрээнд байгуулж ажиллуулах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 107 дугаар захирамжаар "Нүүрсний хулгайн асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үр дүнтэй хянан шалгах, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын хүсэлт, шаардлагын хүрээнд олон нийтийг ил тод, бодитой мэдээллээр хангах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрсний худалдан авалт, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, экспорт, холбогдох зөвшөөрөл, хяналтын асуудлаар Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг байгуулсан.

Энэхүү ажлын хэсгээс "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүд нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт явуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог шинээр байгуулан ажиллуулж, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах" гэсэн санал, дүгнэлтийг 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр гаргасан.

Дээр дурдсан нөхцөл байдал, иргэд, олон нийтийн зүгээс ирүүлж буй хүсэлт, шаардлага, дээрх ажлын хэсгийн санал, дүгнэлтийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог шинээр байгуулах шаардлага гарч байна.

Өмнө байгуулагдсан буюу Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдоор ахлуулсан Хянан шалгах түр хороо нь Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан ба тус тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар энэхүү түр хороо нь "Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох" гэсэн тусгай шалгалтын сэдэвтэй байжээ. Түүнчлэн уг тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу тус Хянан шалгах хороо нь "...тусгай шалгалтын үр дүнг үндэслэн нүүрсний экспортыг сайжруулахтай холбоотой тодорхой саналыг Улсын Их Хуралд танилцуулах" үүрэг бүхий түр хороо байсан байна.

Мөн Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоолоор тус Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 6 сараар буюу 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэл сунгасан нь дуусгавар болсон байх тул тус Хянан шалгах түр хороо нь ажиллах хугацаа болон "нүүрсний хулгай"-н асуудлаар цаашид дагнасан хяналт шалгалт хийх боломжгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулах нь зүйтэй байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөлд дараах агуулгыг тусгана.

1.Хянан шалгах түр хороог байгуулах бүрэлдэхүүн, ажиллах хугацаа;

2.Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаар;

3.Тогтоолыг дагаж мөрдөх хугацаа.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1/Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад гарч болзошгүй авлига, албан тушаал, санхүүгийн гэмт хэрэг болон авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, таслан зогсооход түлхэц болно.

2/Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниуд, ялангуяа төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудад гарсан "Нүүрсний хулгай"-н асуудлаар иргэд, олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй, Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй, гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд тодорхой болно.

3/Хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа "нүүрсний хулгай"-тай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай явуулахад дэмжлэг болно.

4/Уул уурхайн салбар дахь хариуцлагатай төрийн болон орон нутгийн өмчит компанийг хөгжүүлэх, түүний засаглалыг сайжруулах талаас томоохон эерэг нөлөө үзүүлнэ.

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалтын шинжийг агуулж байх тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10-т заасны дагуу уг хуульд заасан судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй болно.

Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Хянан шалгах түр хороо байгуулах тухай"
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэж, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна." гэж тус тус заасан.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад гарч байгаа "нүүрсний хулгай"-н асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь буюу ... гишүүн энэхүү асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниуд, ялангуяа төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудад гарсан "Нүүрсний хулгай"-н асуудлаар иргэд, олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй, Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй, гэмт хэргийн шинжтэй мэдээллүүдийг тодорхой болгох, хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа "нүүрсний хулгай"-тай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах нэн чухал байна.

Үүний тулд Монгол Улсын Их Хурлаас төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 107 дугаар захирамжаар "Нүүрсний хулгайн асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үр дүнтэй хянан шалгах, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын хүсэлт, шаардлагын хүрээнд олон нийтийг ил тод, бодитой мэдээллээр хангах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрсний худалдан авалт, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, экспорт, холбогдох зөвшөөрөл, хяналтын асуудлаар Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг байгуулсан.

Энэхүү ажлын хэсгээс "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүд нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт явуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог шинээр байгуулан ажиллуулж,

цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах" гэсэн санал, дүгнэлтийг 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр гаргасан.

Дээр дурдсан нөхцөл байдал, иргэд, олон нийтийн зүгээс ирүүлж буй хүсэлт, шаардлага, ажлын хэсгийн санал, дүгнэлтийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог шинээр байгуулах нь зүйтэй байна.

Өмнө байгуулагдсан буюу Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдоор ахлуулсан Хянан шалгах түр хороо нь Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан ба тус тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар энэхүү түр хороо нь "Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох" гэсэн тусгай шалгалтын сэдэвтэй байжээ. Түүнчлэн уг тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу тус Хянан шалгах хороо нь "...тусгай шалгалтын үр дүнг үндэслэн нүүрсний экспортыг сайжруулахтай холбоотой тодорхой саналыг Улсын Их Хуралд танилцуулах" үүрэг бүхий түр хороо байсан байна.

Мөн Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоолоор тус Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 6 сараар буюу 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэл сунгасан нь дуусгавар болсон байх тул тус Хянан шалгах түр хороо нь ажиллах хугацаа болон "нүүрсний хулгай"-н асуудлаар цаашид дагнасан хяналт шалгалт хийх боломжгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулаа.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

"Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг хянан шалгах түр хороо байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниуд, ялангуяа төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудад гарсан "Нүүрсний хулгай"-н асуудлаар иргэд, олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй, Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй, гэмт хэргийн шинжтэй мэдээллүүдийг тодорхой болгох, хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа "нүүрсний хулгай"-тай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах шаардлага тулгарсан.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 107 дугаар захирамжаар "Нүүрсний хулгайн асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үр дүнтэй хянан шалгах, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын хүсэлт, шаардлагын хүрээнд олон нийтийг ил тод, бодитой мэдээллээр хангах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрсний худалдан авалт, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, экспорт, холбогдох зөвшөөрөл, хяналтын асуудлаар Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг байгуулсан.

Энэхүү ажлын хэсгээс "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүд нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт явуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог шинээр байгуулан ажиллуулж, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах" гэсэн санал, дүгнэлтийг 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр гаргасан байна.

Дээр дурдсан нөхцөл байдал, иргэд, олон нийтийн зүгээс ирүүлж буй хүсэлт, шаардлага, дээрх ажлын хэсгийн санал, дүгнэлтийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит

хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог шинээр байгуулах шаардлага гарсан.

Өмнө байгуулагдсан буюу Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдоор ахлуулсан Хянан шалгах түр хороо нь Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан ба тус тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар энэхүү түр хороо нь "Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох" гэсэн тусгай шалгалтын сэдэвтэй байжээ. Түүнчлэн уг тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу тус Хянан шалгах хороо нь "...тусгай шалгалтын үр дүнг үндэслэн нүүрсний экспортыг сайжруулахтай холбоотой тодорхой саналыг Улсын Их Хуралд танилцуулах" үүрэг бүхий түр хороо байсан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоолоор тус Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 6 сараар буюу 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр хүртэл сунгасан нь дуусгавар болсон байх тул тус Хянан шалгах түр хороо нь ажиллах хугацаа болон "нүүрсний хулгай"-н асуудлаар цаашид дагнасан хяналт шалгалт хийх боломжгүй болсон байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниудад "нүүрсний хулгай"-тай холбоотой асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах нь зүйтэй гэж үзэж доор дурдсан хуулийн үндэслэл, шаардлагын дагуу "Хянан шалгах түр хороо байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна." гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1-д "Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна." гэж, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.1-д "Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна." гэж, тус хуулийн 34.2-т "Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална." гэж, мөн

хуулийн 34.3-т "Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1, 11.2-т заасан олонх, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 34.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ." гэж тус тус заасан нь тус тогтоолын төслийн үндэслэл, шалгуур болно.

Тогтоолын төсөлд дараах асуудлыг тусгалаа. Үүнд:

1.**Тогтоолын төслийн 1-д** төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог байгуулахаар тусгалаа.

Ингэхдээ Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг хуульд заасан дараах зарчим, шаардлагыг баримтлан байгуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна." гэж, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т "Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална." гэж, мөн зүйлийн 34.1-д "Түр хороо 5 - 19 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно." гэж, мөн зүйлийн 34.3-т "Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1, 11.2-т заасан олонх, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 34.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ." гэж тус тус заасныг баримтлан байгууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.8-д "Хянан шалгах түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулна." гэж заасны дагуу Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 6 сараар тогтоон тусгалаа.

Тогтоолын төслийн 2-т Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.3-т "Энэ хуулийн 33.1-д заасан асуудлаар Улсын Их Хуралд тогтоолын төсөл өргөн мэдүүлэх бөгөөд тогтоолын төсөлд хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана." гэж заасны дагуу хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар тодорхой тусгалаа.

Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг “төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” хувьцаат компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгах”-аар тодорхойллоо.

Тогтоолын төслийн 3-т тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тусгалаа.

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалтын шинжийг агуулж байх тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10-т заасны дагуу уг хуульд заасан судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй болно.

---o0o---

Төсөл

2023-06-26

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр, 6 сарын хугацаатайгаар байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

Цөөнхийг төлөөлөн:

2.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" хувьцаат компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгахаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ